

М. Хурметхан

СИНЬЦЗЯН-УЙГУРЫН АВТОНОМИТ РАЙОНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хятад дахь хятад бус үндэстний талаар маогийнхны явуулж буй улс төрийн бодлого нь их хятадын дээрэнгүй үзлийн ерөнхий шинжүүдээр тодорхойлогдох тул марксизм-ленинизмийн онол, үндэстний асуудлыг шийдвэрлэх ленинч зарчимтай хавьтах зүйл огтхон ч үгүй юм.

Маогийнхны үндэстний бодлогын гол гогцоо нь тэд Гомиьнданаас зээлдэн авсан «нэгдмэл улсын үндэстэн» гэдэг онолын дагуу хятад бус үндэстнүүдийг хүчээр уусгах явдал болж байна. «Улсын үндэстэн» буюу маогийнхны томьёолж байгаагаар «чжунхуа миньцзу» гэдэг онолын гол утга нь юуны өмнө хятадад хятад бус үндэстнүүд оршин байгааг үгүйсгэж, тэдний үндэстний эрхийг үл хайхрах, их хятадын дээрэнгүй үзлийг цагаатгахад оршиж байна. Маогийнхан энэ бодлогоо хэрэгжүүлэхийн тулд хятад дахь хятад бус үндэстнүүд, түүний дотор Синьцзян-Уйгурын автономит районы (СУАР) уугуул ард түмний түүх, одоогийн байдлыг элдвээр гуйвуулан завхруулж байна. Сүүлийн үед хятадын удирдагчид хятад дахь хятад бус үндэстнүүдийн нийгэм-эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх чадваргүй байгаагаа элдвээр нуун далдлахыг оролдож, өөрсдийнхөө ард түмний эсрэг бодлогоо цагаатгахын тулд марксист-ленинист үг өгүүлбэрийг ч хүртэл ашиглаж байна. Социализмын үед ч үндэстний ялгаа тэдгээрийн хоорондох тэгш бус байдал оршин байдаг тухай марксист-ленинист томьёоллоор халхавчлан Бээжингийн их гүрний дээрэнгүй үзэлтнүүд «тэргүүний» хятад үндэстэн, «хоцрогдсон» хятад бус үндэстнүүдийн хоорондох нийгэм-эдийн засгийн ялгаатай байдал урт удаан хугацааны турш үргэлжлэнэ хэмээн үзэж байна. Үүгээрээ тэд хятад дахь хятад бус үндэстнүүдийн нийгэм-эдийн засгийн хоцрогдонгуй байдлыг зөвтгөж тэр хэвээр нь байлгахыг хүсч байна. Үүний зэрэгцээ хятадын удирдагчид хятад бус ард түмнүүдийн олон зуун жилийн түүх, өвөрмөц соёлыг үл тоомсорлох, тэднийг бүхий л хүчээр уусгах явцыг улам хурдасгахыг чармайж байна. Хятадад үндэстний асуудлын талаар тайлбарлаж байгаа тайлбар нь бидэнд уг асуудлын талаар тодорхой төсөөлөх боломжийг олгож байна. Хэрвээ «дөрвийн бүлэг» зөвхөн ангийн тэмцэл оршиж байна гэдэг нэрийдлээр халхавчилж, үндэстний асуудлыг зориуд санаатай гуйвуулах, хятад бус үндэстнүүдэд орон нутгийн буюу районы өөртөө засах эрх олгохоор хятадад үндэстний асуудал аль хэдийн шийдвэрлэгдсэн мэтээр зарлаж байсан бол бээжингийн өнөөгийн онолчид дээрхийн эсрэг хятад ба хятад бус үндэстний тэгш бус байдлыг мөнхжүүлэхийг хүсэж, хятад бус ард түмнийг хятадчилж байгааг халхавчлах, үндэстний асуудал социализм бүх дэлхийн хэмжээнд ялсны дараа ч шийдвэрлэгдэхгүй гэж нотлохыг оролдож байна.

Маогийнхиы үндэстний бодлогын мөн чанар нь хэрэг дээрээ ганцхан зорилгод тухайлбал, хятад дахь хятад бус ард түмнийг аль болохоор богино хугацаанд бүрэн уусган хятадчилахад чиглэгдэж байгаа юм. БНХАУ-ын бодит байдал нь Чжоу Энълайн 1972 онд хийсэн «Хятадад их хан үн-

дэстний дээрэнгүй үзлийг аль хэдийн даван туулсан»¹ гэдэг мэдэгдэлтэй огт нийцэхгүй юм.

1977 оны 8-р сард хуралдсан ХКН-ын XI их хурал ч гэсэн хятадад их хан үндэстний дээрэнгүй үзэл хүчтэй ноёрхсоор байгааг хүлээн зөвшөөрсөн билээ. Үүнийг тус их хурал дээр Хуа Гофэн хэлсэн үгэндээ: «их хан үндэстний дээрэнгүй үзэлтэй тэмцэхэд гол анхаарлаа хандуулах хэрэгтэй»² гэж тэмдэглэсэн нь нотлон харуулж байна. Хятад дахь үндэстний асуудалд гол байр эзэлж байгаа их хятадын дээрэнгүй үзэлтэй тэмцэхийн чухлыг Хуа Гофэн хүлээн зөвшөөрөхийн хамт БНХАУ дахь хятад бус ард түмнүүдийн талаар залхаан цээрлүүлэх арга хэмжээг хүчтэй болгох санаархлаа нуулгүй «орон нутгийн үндэстний үзэлтэй тэмцэх нь чухал»³ гэж мэдэгдсэн билээ.

Мао Зэдүн болон түүний үе залгамжлагчид хятад дахь хятад бус ард түмэнд өөртөө засан тохинох бүрэн эрх олгох, хятад ба хятад бус үндэстнүүдийн хоорондох нийгэм-эдийн засгийн ялгааг устгахын оронд БНХАУ-ын үндэстнүүдийн районы хувьд их хятадын дээрэнгүй үзлийг хүчтэй явуулж байгаа бөгөөд эдгээр районуудын уугуул хүн амыг бүх хэлбэрээр хүчээр уусгах явдлыг ширүүсгэж байна. Мао Зэдүний үндэстний асуудлын талаархи дээрэнгүй бодлогын улмаас хятад дахь хятад бус ард-түмний байдал маш тогтворгүй болж, тэдний улс төр, эдийн засаг, соёлын амьдралд асар их гарз хохирол учрууллаа. Өнөөгийн бээжингийнхэн өөрсдийнхөө их хятадын дээрэнгүй үзлийг бүрхэгдүүлэхийн тулд цаг үеийн арга заль сэдэж байна. Энэ нь нэгдүгээрт: Маогийн үндэстний асуудлаархи бодлогын уналтын бүх бурууг Линь Бяо болон «дөрвийн бүлэгт» тохож тэгснээрээ их хятадын дээрэнгүй үзлийн маоист чиг шугамыг хамгаалан түүнийг хэрэг дээрээ хятадын нөхцөлд үндэстний асуудлыг шийдвэрлэх цорын ганц «зөв чиг шугам» гэж, маогийнхны эсрэг дургүйцэл нь ихээр өрнөж байгаа тус орны зах хязгаарын дагуу оршин суугчдад итгүүлэх; хоёрдугаарт: ХКН-ын VIII их хурлын уг асуудлын талаархи үзэл санааг огоорч тэгснээрээ хятад ба хятад бус үндэстнүүдийн түүхт хөгжлийн түвшингээс шалтгаалан тэдний хооронд буй болсон «бодит тэгш бус байдлыг» даван туулахад хол, үндэстний асуудал социализмын үед ч урт удаан хугацаагаар үргэлжлэнэ гэж батлах; гуравдугаарт: хятад бүр эртнээс нааш нэгдсэн олон үндэстэнтэй улс байсан ба байсаар ч байна. Харин түүний бүрэлдэхүүнд багтсан үндэстэн ястны хооронд сөрөг зөрчилгүй байсан гэж үндэслэхийг хичээж байна. Дөнгөж саяхан дахин засварлаж дууссан хятадын 24 улсын түүх, бас; олон дэвтрээр хэвлэн гаргахаар шийдвэрлэсэн «БНХАУ дахь цөөнх үндэстний товч түүх», «Уйгуруудын товч түүх», «Синьцзян-уйгурын автономит районы товч түүх» зэрэг нь цөм дээрх зорилгод зориулагдсан байна. Эдгээр материалын түрүүчийг 1981 онд хэвлэн гаргахаар төлөвлөжээ;⁴ дөрөвдүгээрт: хятад бус үндэстнүүдэд өөртөө засан тохинох бүрэн эрх олгохоос татгалзах зэрэг болно.

Хятад дахь үндэстний асуудлын талаархи иймэрхүү хандлага нь үндэстний асуудлыг шийдвэрлэх марксист-ленинист зарчим, ЗХУ-д үндэстний асуудлыг шийдвэрлэсэн дэлхий дахины түүхэн туршлагатай нийцэх зүйлгүй юм. ЗХУ болон социалист бусад орнуудад үндэстний асуудлыг шийдвэрлэх ашигтай туршлага, түүний дотор зөвлөлтийн Дунд болон Төв Азийн бүгд найрамдах улсуудын СУАР-д хэрэгтэй туршлагыг бээжингийн удирдагчид ихэмсэг дээрэнгүй зангаар үгүйсгэж байна. СУАР-ы ард түмэн бол зөвлөлтийн дээрх бүгд найрамдах улсуудын ард түмэнтэй гарал угсааны хувьд нийтлэг зүйл олон билээ.

¹The Geographical Journal. Vol. 139. Part 2, June 1973, p. 236

²«Хүнцн», 1977. № 9 (хятад хэлээр) 30-р тал.

³Мөн тэнд

⁴Бээжингийн радио. 1979. IV. 21.

Үүнээс гадна, тэд зөвлөлтийн бодит байдлыг үгүйсгэн ЗХУ-д «их оросын дээрэнгүй үзэл ноёрхож байгаа»¹ мэтээр хуурамч батлагаагаар дайран давшилж байна. Ленинч үндэстний бодлого улам мандаж байгаа дэлхийн ууган социалист орны талаархи маогийнхны иймэрхүү дайралт нь ор үндэсгүй болох нь тодорхой билээ.

БНХАУ-ын өвөрмөц байдалд үндэстний асуудлыг шийдвэрлэх ленинч зарчмыг бүтээлчээр хэрэгжүүлсэн «цорын ганц зөв үлгэр жишээ» мэтээр маогийнхны товойлгон магтаж байгаа орон нутгийн автономи гэдэг нь эхнээсээ аваад эцсээ хүртэл хятад бус үндэстнүүдийн эрх ашгийг бээжингийн эрх баригчдын их хятадын дээрэнгүй үзэлд захируулахад чиглэгдсэн юм.

Хятадын хил хязгаарын районуудын судалгаа, түүний дотор Синьцзяны судлалаар мэргэжсэн америкийн хятад судлагч Джордж Моусли батлан бичихдээ: «хятад бус үндэстнүүдийн орон нутгийн автономи гэгчийг байгуулахдаа гагцхүү хил орчмын районуудад хятад үндэстнийг бодвол учир ялгаатай бодлого явуулахад нь ХКН-д дөхөм үзүүлэхийг зорилго болгосон»² гэжээ. Үндэстний асуудлыг их хятадын дээрэнгүй үзлийн байр сууринаас шийдвэрлэх иймэрхүү хандлагыг төрийн үндсэрхэх үзлийн³ шинж чанарт хамааруулах хэрэгтэй бөгөөд хятадын үндсэрхэх үзэл нь БНХАУ-ын үндэстний районы нийгэм-эдийн засгийн хоцрогдолыг шийдвэрлэж эс чадахаа харуулж байна. Түүнчлэн гаднын нөлөө тухайлбал, ЗХУ-ын зүгээс учирч буй аюул занал гэгчийн улмаас хятадын хил орчмын районуудад буй болсон «онцгой байдал» гэгч маогийнхны ул үндэсгүй нотолгоог няцаах хэрэгтэй юм.⁴

Синьцзяны орон нутгийн хүн ам үй олноороо ЗХУ-д дүрвэн гарсантай холбогдуулан 1964 онд тэр үед БНХАУ-ын засгийн газрын дэргэдэх үндэстний асуудал эрхлэсэн хорооны орлогч дарга Лю Чуньний мэдэгдсэн «онцгой шинэ байдал» гэгчийг өнөөдөр бүр ч хүчтэй хөөргөн дэвэргэж байна.⁵ СУАР-ы «шинэ байдал» болон «стратегийн байрлал» гэгч нь маогийнхны зөвлөлтийн эсрэг чиг шугам, Синьцзяныг ЗХУ-ын эсрэг цэрэг дайны түшиц газар болгон хувиргахад чиглэгдсэн шалтаг болж байна.

Одоо БНХАУ-д үндэстний цөөнхийн асуудлыг хил орчмын районд явуулах ажилтай хослуулан тавьж байна. Хил орчмын ийм ажлын тоонд гадаадын хэвлэлийн бичиж байгаагаар хятад-зөвлөлтийн хилд урьд хятад-энэтхэгийн хил дээр байрлаж байсан 140 мянган хүнтэй дивизийг шилжүүлэн байрлуулах ажил ч багтаж байгаа бололтой. Хилийн районы ажил гэгчид нь бээжингийнхний зүгээс Азийн: өмнөд болон баруун хэсэгт явуулах цэрэг-стратегийн бодлого, юуны өмнө Энэтхэг, Афганистаны эсрэг явуулах бодлогод үйлчлэх зорилготой Кашгарыг Гильгиттэй (Кашмир) холбосон Каракорумын авто зам ч орж байна. Энэтхэгийн олон нийтийн зүтгэлтэн, хятад судлагч-түүхч, д-р Сатьянарян Сина 15 жилийн өмнө «Урьд Өрнөд Дорнодыг холбосон алдарт худалдааны зам одоо Умард-Өмнөдийн цэргийн замаар солигдож Кашгар хотыг Кашмирын Пакистаны хяналтад буй Хунза Гильгитийн районтой холбох болж энэ талаар Пакистаны засгийн газар Энэтхэгийн эсрэг байр сууринаас хятадтай сүлбэлдэж холбогдох хэлэлцээрт хэдхэн долоо хоногийн өмнө гарын үсэг зурав»⁶ гэжээ. Өнөөдөр Каракорумын засмал зам хятадаас хөрш зэргэлдээ

¹The Geographical Journal. Vol. 139. Part 2, June 1973, p. 236

²George Mossely. China's fresh approach to the national minority question: "The China Quarterly" No. 24, 1965, p. 17

³Зөвлөлтийн эрдэмтэн А. Симонягийн тодорхойлсноор их үндэстний дээрэнгүй үзэл нь төрийн үндэстний үзлийн хэв шинж мөн ажээ.

⁴«Хүнц» № 12, 1964 (монгол хэлээр), 40-р тал.

⁵Ж. Лхам. Бээжингийнхний үндэстний бодлогын олиггүй мэх. «Үнэн» 1978. XII 9

⁶Satyanarayan Sinha. "China Strikes". New Delhi. 1964. P. 131.

орнуудын эсрэг өнгөлзөн түрэмгийлэхэд нь үйлчлэх зам болжээ. Синьцзяны нутагт байгуулсан ба байгуулж байгаа цөмийн зэвсгийн барилга төхөөрөмж, пуужинт зэвсэг турших төрөл бүрийн талбай атомын аж үйлдвэр зэрэг цэрэг стратегийн ач холбогдолтой барилга байгууламжийг хэдэн арав, зуугаар нь жишээ болгон дурдаж болно. Гэвч эдгээр нь СУАР-ы эдийн засгийн бэрхшээлийг огтхон ч өөрчлөсөнгүй. СУАР-ы эдийн засгийн хөгжил нь бүхэлдээ цэрэг-колони орны байдлаар үлдэж соёлын хувьд гэвэл байдал түүнээс ч муу байна. Синьцзянд одоо хүртэл уйгур хэлээр мэргэжлийн зохиолчийн бичсэн ганц ч роман гараагүйгээр барахгүй томоохон тууж өгүүлэл ч алга байна. Яруу найрагчдын уран бүтээл нь тэр аяараа Мао Зэдүнийг бишрэн магтахад чиглэгдэж, уйгурын ард түмний эртний дуу шүлгийн хуучин үгийг «мао даргыг» шагшин магтсан шинэ үгээр сольжээ.¹ СУАР-д оршин сууж байгаа зургаан сая хүнтэй уйгурын ард түмний дотор эрдмийн зэрэгтэй хүн ганц ч байхгүй байна.² Харин хятадын дүрс бичгийн авианы дүрслэл дээр тулгуурласан хятадчилсан латин үсгийг албаар нэвтрүүлснээс болж Синьцзяны хүн амын олонхи хэсэг аанай л бичиг үсэггүй хэвээр байна. Энэхүү анх 1971 онд Хятадын ардын чөлөөлөх армийн цэргүүд Синьцзянд нэвтрүүлсэн шинэ бичиг нь Синьцзянд нутаглаж буй уйгур, казах, киргиз зэрэг хятад бус ард түмний хэл авианы онцлогийг тусгаж чадаагүйг хэлэх хэрэгтэй билээ. СУАР-ы нийгэм, улс төрийн төдийгүй аж ахуйн бүтцийг үзсэн ч БНХАУ үндэстний районуудынхаа нийгмийн амьдралыг хэрхэн цэрэгжүүлж байгаа төрх байдал нь тод томруун харагдана. СУАР-д коммун буюу үйлдвэрт ажиллаж байгаа 16—45 насны эрэгтэй, 16—35 насны эмэгтэйчүүд өрхийн цэрэгт бүртгэгдсэн хийгээд аж үйлдвэрийн салаа бүр өрхийн цэргийн роттой байна. Үйлдвэрийн бригад бүр зэвсэгт салаа ба өрхийн цэргийн нэгэн сумантай, коммун бүр өрхийн цэргийн хороотой байх ёстой ажээ.³ Хэрэв 1975 онд өрхийн цэргийн тоо 2,2 сая буюу бүх хүн амын 25,2 хувийг хамарч байжээ.⁴ 1975 онд 9 сая хүн амтай байх үеийн өрхийн цэргийн тоог 1979 онд 11 сая хүн амтай болсон баримттай жишиж үзвэл одоо СУАР-д өрхийн цэргийн тоо даруй 3 саяд хүрсэн ажээ. Энэхүү 3 сая өрхийн цэргийн 70 хувийг СУАР дахь хятад бус үндэстнүүд эзэлж байна. Өрхийн цэрэг гэгчээс гадна ХАЧА-ийн үйлдвэрлэл-барилгын корпуст ажиллагч 1,5 сая хүн цөм л цэргийн албан хаагчид юм. (Хүний тоо нь 1975 оны баримт болно-М. Х.). Дашрамд тэмдэглэхэд гоминьданы цэргийн үлдэгдэл болон ХАЧА-ийн халагдсан цэргүүдээс бүрдэл болсон эдгээр корпус иь нэг талаар цэргийн, нөгөө талаар үйлдвэрлэлийн нэгж гэгдэх бөгөөд одоо үед тэднийг цэргийн сангийн аж ахуй гэж нэрлэж байгаа боловч энэ районы цэргийн тойрогт шууд захирагдсан хэвээр байна. СУАР-ы нийгэм эдийн засгийн харилцааны товч төлөв иймэрхүү байна.

Америкийн хятадыг судлагч нэрт эрдэмтэн О. Латтимор анх 1927 онд Синьцзянд ирж 45 жил өнгөрсний дараа 1972 онд энэ нутагт дахин очсон бөгөөд «Pivot of Asia: Sinkiang and the Inner Asian Frontiers of China and Russia» (New York, 1975) гэдэг номынхоо шинэ хэвлэлд зориулан товч тодорхой оршил бичиж Синьцзяны урьдах үеийг бодвол хятадтай улам бат хүлэгдэж, үнэхээр өөрийнхөө түүхэнд урьд үзэгдээгүйгээр түүнд татагдан нийлсэн тухай үзсэн харснаа бичсэн байна. Зохиогч «нийлсэн» гэдэг нэр томъёог эдийн засаг, улс төр болон үндэстний бүх асуудлыг хамарсан хамгийн өргөн хүрээтэйгээр авч хэрэглэсэн нь үзтэл илэрхий байна. Тэрчлэн үндэстний хувьд явуулах хятадын улс төрийн

¹М. Хамраев Веков неумирающее слово. Алма-Ата, 1969. 198-р тал

²М. Рузнев. Возрожденной уйгурский народ. Алма-Ата 1976. 206-р тал.

³J. Esposito. The Militiaman of Sinkiang:—“Asia Quarterly”, Bruxelles, 1977, N 2 p. 166

⁴Ibid., p. 164.

бодлогод «нийлэх» гэдэг үг эх орны «нэгдмэл» байдал (мөн улс үндэстний) гэсэн утгыг агуулдаг бөгөөд энэ нь хятад бус үндэстнүүдийг хүчээр уусгах их хятадын дээрэнгүй үзлийг хэрэгжүүлэх гол зэвсэг гэдгийг ухахад төвөггүй билээ.

Үүний зэрэгцээгээр «эх орны нэгдмэл» байдлыг хангах гэсэн маоист лоозон бол бас өөр нэгэн маш чухал түүгээр ч барахгүй бараг гол нэгэн утга агуулж байгаа нь юу вэ? гэвэл БНХАУ-ын автономит районы нутаг дэвсгэрийг бусад орон руу халдан түрэмгийлэх цэргийн түшиц газар болгож тухайлбал СУАР-ы нутаг дэвсгэрийг ЗХУ, БНМАУ-ын эсрэг явуулах дайны бэлтгэл хийх «цайз» болгох гэсэнд оршино. Үүнийг маогийнхнаас 1976 онд Өрөмч хотод зохион явуулсан СУАР-ы «бичиг үсэгтэн» залуучуудын анхдугаар хурал гэгчээс гаргасан уриалга ч батлах бөгөөд автономит районы олон үндэстэн ястны 830 төлөөлөгч оролцсон уг хурлын урилгад Синьцзяныг заавал «ревизионизмтэй тэмцэх, ревизионизмаас хамгаалах эвдрэшгүй ган болд хэрэм» болгож хувиргах хэрэгтэй гэжээ.¹ Маогийнхан цэрэг дайны ийм хэнээрхлийн дор СУАР-ыг цэрэгжүүлж, түүний нутаг дэвсгэрийг дайны түшиц газар болгон хувиргаж байгаагийн улмаас Синьцзяны уугуул хүн амын аж байдал, амьдралын түвшин өөдлөхгүй байна. Үүнтэй холбогдуулан 1977 онд Синьцзянаас дүрвэн гарсан, энэ нутгийн бодит байдлыг нүдээр үзсэн хүний үгийг жишээ болгоё. Тэрний хэлж байгаагаар нэг айлын насанд хүрсэн хүн бүр жилд малгай, бүс, цамц мэтийн хувцас хунарын зүйл хийхэд зориулж 9 метр бөс даавуу авах талон, сард нэг кг мах, 15 кг будаа авах талонтой байдаг бөгөөд үүр цайхаас үдшийн бүрий болтол ажиллаж зөвхөн өвлийн улиралд 10 хоногт 1 удаа амрана. Эмнэлгийн газар хэвтэж байгаа өвчтөн гэрээсээ хоол зөөлгөж идэх ёстой гэж ярьж байна. Өөр нэг дүрвэгч, тэнд малчин байсан хүний ярьснаар малчдын гэр нь хар овоохой болж хувирсан хийгээд хилийн орчим байгаа малчид малыг хятад харгалзагч нарын хяналтын дор хариулдаг ажээ. Тэдний коммуны хоёр их бригад хятадуудаас бүрдсэн хийгээд тус коммуны хүн амын 2-ын нэг нь хятад байна. Нүүж ирсэн хятадуудад коммуны өөрийн хүчээр байр сууцыг бэлтгэн олгодог байна. Ингэж нутгийн гүнээс хятадуудыг бөөн бөөнөөр нь нүүлгэн ирүүлж суурьшсаны улмаас, 1949 онд Синьцзянд хятад хүн дөнгөж 3 хувийг эзэлж байсан бол хятадуудын эзлэх хувийн жин түргэн нэмэгдэж бүр 1966 онд бараг 45 хувийг эзлэх болсон нь² Синьцзяны уугуул хүн амыг аль болох хурдан хятадчилахыг маогийнхан зорьж байгааг гэрчилж байна. Үүгээр барахгүй цаашид СУАР-д 70 саяас 100 сая хятадуудыг³ нүүлгэн суурьшуулахыг маогийнхан төлөвлөж байна. Маогийнхны энэ мэт доромжлол нь СУАР-ы хятад бус ард түмнүүдийн хурц ширүүн дургүйцэлтэй тулгарсаар байна. Тухайлбал 1962 онд 65000 казах, уйгурууд амь зуух эрхээр төрсөн нутгаа орхин өөдтэй амьдрал мөрөөдөж ЗХУ-д тийнхүү олноор дүрвэн гарсны шалтгаан нь аанай л Бээжингийнхний их хятадын дээрэнгүй үзэл байсан юм. Тайваний хэвлэлийн мэдээнээс үзвэл 1978 оны 2-р сарын эцсээр СУАР-д орон нутгийн ард түмний зэвсэгт бослого гарчээ. Бослого Авати хошуунд эхлэж удалгүй Аксу, Капин болон Уши хошуунд тархжээ. Босогчид маогийнхны засаг захиргааны болон намын байгууллагуудын байрыг дайрч, зэвсгийн агуулахыг эзлэн авчээ. Бослогыг «Синьцзяны үндэстний нэгдсэн журамт цэргийн хүчээр зохион байгуулсан байна»⁴. 1978 оны 2-р сарын 29-нд ХКН-ын Төв Хороо, ХКН-ын Төв хорооны цэргийн

¹Информационные материалы. М., 1976, 1 квартал. 31—32-р тал

²Опасный курс. Выпуск первый М., 1969. 197-р тал.

³Бюллетень информации АПН. № 70 (387).

⁴Синь Дао жибао., 1978. III. 31.

зөвлөл зэвсэгт бослогыг хайр найргүй «хүчлэн дарах» шийдвэр гаргажээ. Бослогыг ХАЧА-ийн ангиудын хүчээр дарсан байна.

Өнгөрсөн онд Хуа Гофэн СУАР-ыг «их хор хөнөөл амссан»¹ район гэж хүлээн зөвшөөрсөн явдал нь маогийнхны их хятадын дээрэнгүй үзэл нь тус районы, ялангуяа түүний үндсэн хүн амын улс төр, эдийн засаг, соёлын амьдралд хэмжээлшгүй гарз хохирол учруулсныг харуулж байна. Синьцзян дахь хятад бус ард түмнүүд эзлэн түрэмгийлэгчид болон үндэсний дарлан мөлжигчдийн эсрэг тэмцэж байсан түүхийн баялаг уламжлалтай юм. Энэ талаар зөвхөн XIX зуунд Синьцзянд гарсан долоон том бослогыг (1814, 1830, 1864 г. м.) дурдахад хангалттай юм. Тэдгээрийн гол хөдлөх хүч нь хятадын колоничлогчид ба дотоодын феодалуудын эсрэг боссон уйгурын тариачид байлаа. Тэдний бослогыг хятадын Чин улсын ноёрхогч ангиас хатуу ширүүнээр дарж байсан учир үндэстний цөөнхийн байдал урьдын адил туйлын хүнд хэвээр байжээ.²

Сүүлийн 100 жилд энд 400 орчим зэвсэгт бослого гарсны дотор хамгийн том нь 1944 оны бослого байв. Босогчид гоминьданыхнаас (Илн, Алтай, Тарвагатай) зэрэг аймгийг чөлөөлж Дорнод Туркстаны Бүгд Найрамдах Улсыг тунхагласан юм. 1949 оны 10-р сард Синьцзяны нутагт гоминьданы дээрэмчдийн үлдэгдлийг устгах нэрийдлээр орж ирсэн ХАЧА-ийн ангиуд Дорнод Туркстаны Бүгд Найрамдах Улсыг хэрэг дээрээ бүрэн устгасан юм. СУАР-ы үндсэн хүн ам эдүүгээ хүртэл өөрсдийнхөө өөрөө засан тохинох бүрэн эрхийн төлөө, жаргалант ирээдүйнхээ төлөө маогийнхны их хятадын дээрэнгүй үзэл, хүчээр уусгах бодлогын эсрэг тасралтгүй тэмцэл явуулж байна.

М. Хурметхан

СОВРЕМЕННОЕ ПОЛОЖЕНИЕ СИНЬЦЗЯНО-УЙГУРСКОГО АВТОНОМНОГО РАЙОНА

Р е з ю м е

Автор статьи, анализируя современное положение Синьцзяно-Уйгурского автономного района (СУАР), раскрывает шовинистическую сущность национальной политики маоистов.

Стержнем национальной политики маоистов является насильственная ассимиляция неханьских народов в соответствии с заимствованной ими из архивов Гоминдана «теорией единой государственной нации» (Гоцзу), Суть теории «государственной нации», которая в настоящее время трактуется маоистами под названием «чжунхуа миньцзу», заключается, прежде всего, в игнорировании самого существования неханьских народов, их национальных прав стем, чтобы оправдать великоханьский шовинизм.

Такой маоистский подход к национальному вопросу в Китае совершенно несовместим с марксистско-ленинскими принципами решения национального вопроса и игнорирует всемирно-исторический опыт СССР по решению национального вопроса. Пекинские лидеры высокомерно охаивают полезный опыт решения национального вопроса в СССР и других братских стран социализма, в частности, опыт советских республик Средней Азии для СУАР.

¹ ИБАС, № 6987. 1978. IX. I

² Цит. М. Хамраев. «Веков неумиравщес слово» Алма-Ата, 1969. 63-р тал.

Автор опровергает нападки маоистов на ленинскую национальную политику в СССР как грубую беспочвенную клевету на советскую действительность.

В статье отмечается, что факты наличия в Китае великоханьского шовинизма были признаны XI съездом КПК, на котором Хуа Гофэн говорил о какой-то «борьбе» с великоханьским шовинизмом, но в то же время он не скрывал своего намерения усилить репрессивные меры в отношении неханьских народов КНР под предлогом «необходимости борьбы с местным национализмом».

О насильственной ассимиляции народов Синьцзяна свидетельствует планомерное массовое переселение туда ханьцев, принудительное введение в их язык китайских слов, запрещение употребления многих слов родного языка, оскорбление религиозных чувств, ущемление их национальных прав, традиций и обычаев.

Как и другим национальным районам, СУАР отводится особая роль в осуществлении экспансионистской политики в отношении соседних государств. Милитаризация этого района, издавна начатая китайскими руководителями, превратила Синьцзян в военный плацдарм против соседних стран в первую очередь СССР и МИР, что, естественно, отрицательно сказывается на социально-экономическом положении коренного населения Синьцзяна. Тотальная мобилизация коренных жителей на строительство военных объектов, дорог, аэродромов и их бесправное положение вызывает глубокое недовольство среди неханьских народов Синьцзяна.

Обстановка в национальных районах Китая продолжает оставаться нестабильной, о чем свидетельствуют вооруженные выступления неханьских народов СУАР в феврале 1978 г. в уездах Авати, Аксу, Катине и Уше.

В заключение говорится, что неханьские народы Синьцзяна имеют большую традицию борьбы против великоханьского шовинизма за национальное самосуществование.